



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№142 /356/

2022.08.12

Цаг үе, үйл явдал

ОЛОН УЛСЫН ТЭМЦЭЭНИЙ БЭЛТГЭЛИЙГ ХАНГАСААР БАЙНА



“Дом дружба” хэмээх хээрийн ордонд “13 дугаар зууны морьтон дайчид” сэдэвт үзэсгэлэнгээ дэглэж эхэллээ. Энэхүү “Армийн соёл, урлаг” тэмцээний төрөлд нийт 17 орны 127 оролцогч дуу, хөгжим, бүжиг, музейн үзэсгэлэн төрлөөр өрсөлдөж байна. Дээрх тэмцээнүүдэд оролцох Зэвсэгт хүчний багийг ахалж яваа бүрэлдэхүүн Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Элчин сайд Э.Энхтүвшинд бараалхан тэмцээнд оролцох бүрэлдэхүүн, тэдний бэлтгэлээ хангаж буй байдлын талаар мэдээлэл хийсэн. Уулзалтын эхэнд бригадын генерал С.Дашзэвэг “Олон улсын цэргийн наадам”-ын талаар мэдээлэл өгсний зэрэгцээ Монгол Улсын

Зэвсэгт хүчний баг тамирчдын өмнөх жилүүдэд оролцсон төрлүүд, гаргасан амжилт болон энэ удаагийн тэмцээний онцлог, багийн гишүүдийн талаар танилцууллаа. Элчин сайд Э.Энхтүвшин баг тамирчдад амжилт хүсэхийн зэрэгцээ тэмцээнд амжилттай оролцоход шаардагдах бүхий л талын тусламж, дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн юм. Уулзалтад Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташе хошууч генерал Р.Сүхбат оролцлоо.

Хурандаа Д.ЭРДЭНЭБИЛЭГ

ОХУ-ын нийслэл Москва хотноо 2022 оны 8 дугаар сарын 13-28-ны өдрүүдэд зохион байгуулагдаж буй “Олон улсын цэргийн наадам-2022”-ын хүрээнд “Танкийн биатлон” болон “Армийн соёл, урлаг” тэмцээнд өрсөлдөх Монгол Улсын Зэвсэгт хүчний баг, тамирчид бэлтгэлээ хангасаар байна. “Олон улсын цэргийн наадам”-ыг зохион байгуулах хорооны гишүүн, Монголын талын дарга,

Зэвсэгт хүчний Жанжин Штабын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг уг наадмыг зохион байгуулах хорооноос явуулж буй сургалтад хамрагдаж, тэмцээний шүүгчийн эрхийн сертификат, 3 дугаар зэрэглэлийн шүүгчийн тэмдгээ гардан авлаа. Мөн “Армийн соёл, урлаг” тэмцээний музейн үзүүлэлийн төрөлд оролцох баг Алабино дахь



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 22	🌧️ 10

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 28	🌧️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.195.00	3.202.0
EUR 🇪🇺	3.300.0	3.315.0
CNY 🇨🇳	474	477
RUB 🇷🇺	49.80	50.50
JPY 🇯🇵	23.70	24.10
KRW 🇰🇷	2.43	2.45

ЗУРХАЙ



2022.08.12 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 15

ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САРЫН ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал: Өлзийтэй сайн НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 05.43-20.12 БАРИЛДЛАГА: Идэр Шүтэн барилдлага: Төрөхүй Суудал: Уул

Энэ өдөр үхэр, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, лусыг тахиж, хагалгаа хийлгэх, буг дарах, газрын ам бооход сайн. Мод суулгах, нарийн зөвлөгөөн хийх, сэтгэлд сэвтэй газар очих, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.

“ЦЭРГИЙН РАЛЛИ 2022” ТЭМЦЭЭНИЙ БЭЛТГЭЛ АЖИЛ БҮРЭН ХАНГАГДЛАА

Олон улсын цэргийн хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх зорилготой “Олон улсын цэргийн наадам”-ын хүрээнд явагддаг “Цэргийн ралли” тэмцээн Монгол Улсад анх удаа зохион байгуулагдана. Тодруулбал, тус тэмцээний нэгдүгээр шат буюу “Нэг бүрийн уралдаан” Увс аймгийн Улаангом суманд 8 дугаар сарын 12-16, хоёрдугаар шатны “Нэхэн хөөх уралдаан”, гуравдугаар шатны “Багийн уралдаан”, дөрөвдүгээр шатны “Буудлага”-ын тэмцээн 8 дугаар сарын 16-22-ны өдрүүдэд ОХУ-ын Бүгд Найрамдах Тува Улсын нийслэл Кызыл хотод явагдахаар төлөвлөгдсөн юм. Тэмцээнд Монгол Улс, ОХУ, Беларусь, Узбекистан улсын баг тамирчид оролцоно. Монгол Улсын тухайд тус тэмцээнд хоёр дахь удаагаа авхаалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдөнө. Уралдааныг зохион байгуулах хорооны штабын дарга хурандаа Д.Хаш-Эрдэнээс тэмцээний талаар тодрууллаа.



Д.Хаш-Эрдэнэ: БАЙГАЛИЙН БҮХИЙ Л ТӨРЛИЙН СААД, БАРТААТАЙ ГАЗАР ОРНЫГ СОНГОЖ АВСАН



“Цэргийн ралли 2022” тэмцээний онцлог нь юу вэ? -Мэдээж тус тэмцээн Монгол Улсад анх удаа, тэр тусмаа баруун бүс Увс аймагт зохион байгуулагдаж байгаагаараа онцлог. Уралдааны маршрутын тухайд уулархаг, байгалийн бүхий л төрлийн саад, бартаатай 77 км газрыг сонгож авсан. Бэлтгэл ажлын талаар мэдээлэл өгөхгүй юу? -“Цэргийн ралли 2022” тэмцээний нэгдүгээр шатны бэлтгэл ажлыг Зэвсэгт хүчний 20 гаруй анги, байгууллагын 200 орчим бие бүрэлдэхүүн 14 хоногийн хугацаанд бүрэн хангасан. Баг тамирчдын байрлах байр, автомашины зогсоол

зэргийг бүрэн тохижуулж, тэмцээний хүрээнд зохион байгуулагдах бэсрэг наадам, бусад урлаг соёлын арга хэмжээний бэлтгэлийг хангаад байна. Бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлсэн орон нутгийн удирдлага, төрийн захиргааны байгууллага, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдад талархал илэрхийлж. “Цэргийн ралли 2022” тэмцээнд оролцох улс орны баг тамирчид өнөөдөр Монгол Улсад хүрэлцэн ирнэ.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 592,904,427

Эдгэрсэн

Нийт: 564,834,768

Нас барсан

Нийт: 6,447,993

УРАЛДААН БАЙГАЛИЙН ҮЗЭСГЭЛЭНТ ГАЗРУУДААР ЯВАГДАНА



"Аравт" олон улсын морин цэргийн уралдаан зохион байгуулах хорооны дарга, ерөнхий шүүгч, хурандаа Д.Цог-Эрдэнэ, хорооны штабын дарга, хурандаа Ш.Гантулга тэргүүтэй ОХУ, Узбекистан, Бүгд Найрамдах Зимбабве Улсын багийн ахлагч, дасгалжуулагч, тасгийн дарга

нар өнөөдөр алсын зайн марш явагдах газар болон үүрэг биелүүлэх цэгүүдийн тохижилттой танилцлаа. Энэ үеэр хурандаа Д.Цог-Эрдэнэ уралдааны цэгүүдийг төхөөрөмжлөн, тохижуулсан Зэвсэгт хүчний 014, 015, 284, 084, 310 дугаар ангийн удирдлагуудад сайн ажилласныг тодотгоод

уралдаанд оролцогчдоос гадна тэднийг дагалдаж, хяналт тавих бүрэлдэхүүний амрах байртай танилцаж, өөрсдийн нөөц бололцоогоор тэмцээнийг амжилттай зохион байгуулахаар хичээж буйд нь талархал илэрхийлэв. Ташрамд дурдахад, алсын зайн марш нь Хустайн нуруу, Молцог элс зэрэг байгалийн үзэсгэлэнт газраар

дамжин явагдана. Энэ нь гаднын цэргүүдэд эх орноо сурталчлах бас нэг алхам билээ.

Түүнчлэн "Аравт-2022"-ын олон улсын морин цэргийн уралдааны арын албанд Монгол Улсын Зэвсэгт хүчний анги, байгууллага бүр өөрийн чиглэл үүргийнхээ хүрээнд оролцож байна.

Тухайлбал, алсын зайн маршийн маршрутын үед гүйцэтгэх таван цэгт Зэвсэгт хүчний таван ангийн томилогдсон бүрэлдэхүүн ажиллаж байна.

Тэд маршийн цэгүүдийн тохижилтыг гүйцэтгэж, төхөөрөмжлөн уралдаан явагдах нөхцөлийг

бүрэн хангаад байна. Алсын зайн маршийн ус гатлах цэгт Зэвсэгт хүчний 014, морь сэлгэх цэгт Зэвсэгт хүчний 015, морин эргүүлийн цэгт Зэвсэгт хүчний 284, хээрийн хоноглолтын цэгт Зэвсэгт хүчний 084, шархтанд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, шархтан, сум, галт хэрэглэлийг хөнөөлийн голомтоос татан гаргах цэгт Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн томилогдсон бүрэлдэхүүн ажиллаж байгаа юм.

Тус уралдаан Зэвсэгт хүчний "Сургалтын нэгдсэн төв"-ийг түшиглэн явагдаж, уралдаанд оролцох агт морьдын маллагааг Зэвсэгт хүчний 232 дугаар анги, нээлт,

хаалтын ажиллагааны үеэр морин дээрх хөгжимтэй үзүүлэх тоглолтыг Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн морьтон дайчид хариуцан ажиллаж байгаа юм.

Мөн "Аравт"-ын арын албаны гол ажлыг Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд болон БНӨСУ-д үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний XI ээлжийн цэргийн алба хаагчид нугалж байгаа юм.

"АРАВТ-2022" ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БҮЛЭГ



Цахим шууданд

"ААЖУУ ЯВБАЛ АЯНДАА ХҮРНЭ ДЭЭ" БИД НЭГДЭЖ БАЙНА



Улсын хэмжээнд зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулагдаж буй "Аажуу явбал аяндаа хүрнэ дээ" нэгдсэн арга хэмжээний хүрээнд Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон тус дүүргийн Цагдаагийн газар хамтран төрийн байгууллагуудын дунд "Туг" аялуулах арга хэмжээг зохион байгуулж байна.

Урин дулаан цаг болсонтой холбоотойгоор хөдөө, орон нутгийг зорих замын хөдөлгөөн нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор Цагдаагийн Ерөнхий газрын Тээврийн цагдаагийн

албанаас улсын хэмжээнд зам тээврийн осол гэмтлийн улмаас иргэдийн амь нас, эд хөрөнгө хохирохоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөн оролцогчдын буруу дадал хандлагыг өөрчлөх, зөв үйлдэлд уриалах зорилгоор "Аажуу явбал аяндаа хүрнэ дээ" аяныг зохион байгуулж байгаа билээ.

Тус аянд ҮБХИС нэгдэн байгууллагуудад аялж буй тугийг хүлээн авч доорх ажлуудыг хэрэгжүүлж жолооч нарт сэрэмжлүүлэг хүргүүлээ.

Орон нутгийн замд гарч байгаа жолооч та

- Хурд хэтрүүлэхгүй байх
- Гүйцэж түрүүлэх үйлдэл

хориглосон нөхцөлд хийхгүй байх

•Бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй хол замд гарахгүй байх

•Жолоочийн нойр дутуу ядарсан үед жолоо барихгүй байх

•Архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ жолоо барихгүй байх

•Жолооч биш хүнд жолооч шилжүүлэхгүй байхыг зөвлөн сэрэмжлүүлж байна.

Хөдөө орон нутгийг зорихоор замд гарсан жолооч та анхаарал болгоомжтой замын хөдөлгөөнд оролцож болзошгүй эрсдэл бүхнээс өөрийгөө болон өрөөлийг хамгаалаарай.

АНГИЙН 40 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД СУРТАЛЧЛАХ ӨДӨРЛӨГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛНА

Зэвсэгт хүчний 284 дүгээр анги

Зэвсэгт хүчний байр зүйн албаны 90, Зэвсэгт хүчний 284 дүгээр анги үүсэн байгуулагдсаны түүхт 40 жилийн ой ирэх 9 дүгээр сард тохионо.

Ойн хүрээнд ангийн хамт олон бүтээлч ажлуудыг өрнүүлж байгаа бөгөөд эдгээр ажлаа олон нийтэд хүргэх үүднээс ирэх сарын 2-ны өдөр сурталчлах өдөрлөгийг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Тус сурталчлах өдөрлөгийн хүрээнд "Цэргийн байр зүйн алба, байр зүй, геодезийн тусгай батальоны үүсэл хөгжил, ирээдүйн чиг хандлага" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг энэ сарын 18-ны өдөр Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургуулийн "Сүбэдэй" хурлын зааланд зохион байгуулна.



Мөн Монгол цэргийн музейд цэргийн байр зүйн алба, ангийн үйл ажиллагааг

харуулсан "Байр зүйчдийн булан" байгуулахаар ажиллаж байна.

Ахлах дэслэгч М.ОЧГЭРЭЛ



ТАНЫ АЛТАН ШАР ЗАМ ӨЛЗИЙТЭЙ БАЙГ

Дарга, ерөнхий редактор, хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ**

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)